



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2025.06.18 № 22

Г ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,  
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД  
Б.ДЭЛГЭРСАЙХАН ТАНАА

Г Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн Т  
авто замын талаар

Монгол Улсын хэвтээ тэнхлэгийн А/0502 дугаартай Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн Улаанбаатар хотоос 394-440 дэх 50 км хатуу хучилттай авто замын ажлыг “Чайна Гео Инженеринг” ХХК-аар, мөн чиглэлийн Өндөрхаан хотоос 271-298 дэх 27 км хатуу хучилттай авто замын ажлыг “Хансуун зам” ХХК-аар Улсын төсөв, Хөгжлийн банкны санхүүжилтээр гүйцэтгүүлэх гэрээг 2013 онд Зам, тээврийн яам байгуулсан байдаг. Мөн дээрх замын ажлуудыг гүйцэтгэхэд захиалагчийн хяналтыг тус яам хэрэгжүүлсэн.

Тус ажлуудыг гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийн барьсан авто зам нь анхнаасаа чанар, стандартын шаардлага хангаагүйн улмаас эвдрэл, гэмтэл ихээр үүсэж зам, тээврийн осол олноор гарч иргэд, зорчигч, жолооч нарын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учирсаар байна.

Улсын чанартай эдгээр авто замын урсгал засвар, арчлалтыг Зам, тээврийн яамнаас хариуцан хийх зохицуулалттай ч Улсын комисс байнгын ашиглалтад аваагүй шалтгаанаар дээрх замуудын засварын ажилд хөрөнгө зарцуулах боломжгүй тухай тайлбарыг яамнаас өгсөн.

Замын ажлыг гүйцэтгэгч хуулийн этгээдүүд болон Зам, тээврийн яамны тухайн үеийн холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах, хохирлыг барагдуулах асуудлыг шийдвэрлүүлэхээр орон нутгийн засаг захиргаанаас удаа дараа хууль, хяналтын байгууллагуудад хандсаар ирсэн. Мөн Зам, тээврийн яам гүйцэтгэгч компаниудаас хөрөнгө нэхэмжилж шүүхэд хандсан байдаг.

Зам, тээврийн яам, түүний харьяа байгууллагуудаас дээрх замуудын эвдрэл, гэмтэлд хэмжилт тооцоолол хийж, их засвар, шинэчлэлт хийх тухай дүгнэлт гарган, зураг төсвийг гаргуулснаар 50 км авто замын их засвар, шинэчлэлийн ажлыг Дэлхийн банкны зээлийн хөрөнгөөр, 27 км авто замын ажлын их засвар, шинэчлэлийг Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр Улсын Их Хурлаас 2024 онд шийдвэрлэсэн.

Тус замуудыг 2013-2014 онд барих үеийн чанар, стандарт, түүнтэй холбогдуулан гаргасан гомдол, маргаан хэрхэн шийдвэрлэгдсэн талаар болон тус авто замуудын их засвар, шинэчлэлтийн ажлын одоогийн явц байдал, 2025 оноос эхлэн хийх их засвар, шинэчлэлтийн ажлын тендер шалгаруулалтын явц, үр дүн,

2025000034

зураг төслийн төлөвлөлт, авто замын хүчилтын хийцлэл, техник технологийн хяналтыг хэрхэн төлөвлөсөн талаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна.

Нэг: Хэвтээ тэнхлэгийн А/0502 дугаартай “Чайна Гео Инженеринг” ХХК-ийн 2013-2014 онд гүйцэтгэсэн Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн Улаанбаатар хотоос 394-440 дэх 50 км авто зам, “Хансуун зам” ХХК-ийн 2013-2014 онд гүйцэтгэсэн Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 271-298 дэх 27 км хатуу хүчилттай авто замын тухайд:

1.1. Энэ авто замуудын барилгын ажлыг хүлээн авсан Улсын комисс, Техникийн комиссын шийдвэр болон холбогдох бусад мэдээлэл;

1.2. Тус авто замуутдай холбогдуулан хууль хяналтын байгууллагад гаргасан гомдол, маргааны шийдвэрлүүлэлтийн талаарх мэдээлэл;

1.3. Дээрх авто замуудын барилгын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн “Чайна Гео Инженеринг” ХХК, “Хансуун зам” ХХК болон техник, технологийн хяналт хэрэгжүүлэн ажилласан байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцох, асуудлыг шийдвэрлэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар;

1.4. Тус ажлуудын гүйцэтгэлийг хэрхэн хянасан, гэрээнд заасан үнийн дүнгийн хэдэн хувийг хэзээ олгосон талаарх мэдээлэл;


1.5. Тухайн авто замуудад 2025 оноос эхлэн хийх их засвар, шинэчлэлтийн зураг төслийн төлөвлөлт, авто замын хүчилтын хийцлэлийг хэрхэн төлөвлөсөн талаар болон өмнө гарсан алдаа дутагдлыг запруулах талаар ямар арга хэмжээ авч байгаа талаар;

1.6. Энэхүү замын ажлуудыг гүйцэтгэх хуулийн этгээд болон техник технологи, чанарын хяналтыг гүйцэтгэх этгээдийг хэрхэн сонгосон, мөн ажил гүйцэтгэх болон хяналт хэрэгжүүлэх ажлын гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдийн чадамжийн талаарх тодорхой мэдээлэл;

Энэхүү асуулгын хариуг Байнгын хороогоор хэлэлцүүлэх тул Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасны дагуу ирүүлэхийг Танаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

М.БАДАМСҮРЭН



2025000034